

UNIVERSITY OF CALIFORNIA, SAN FRANCISCO

**ТУРШИЛТЫН ОРОЛЦОГЧИЙН
ЭРХИЙН ТУХАЙ МЭДЭГДЭЛ**

Доорх эрх нь судалгаанд хамрагдахыг хүссэн хүн бүрийн эрх юм. Туршилтын оролцогч би дараах эрхтэй.

- 1) Судалгаагаар юу олж мэдэхийг хүсэж байгааг мэдэх,
- 2) Надад юу тохиолдох, шинжилгээ, эм эсвэл багаж төхөөрөмжийн аль нэг нь стандарт практикт ашиглахаас өөр эсэхийг мэдэх,
- 3) Судалгааны зорилгоор надад тохиолдох зүйлсийн давтагддаг болон/эсвэл чухал эрсдэл, гаж нөлөө эсвэл зовуурийн талаар мэдэх,
- 4) Оролцсоноор ямар нэгэн ашиг тус гарах, хэрэв тийм бол ямар ашиг тус гарч болох талаар мэдэх,
- 5) Надад байгаа бусад сонголт, тэдгээр нь судалгаанд хамрагдахаас дээр эсвэл дэмий байж болох талаар мэдэх,
- 6) Судалгаанд хамрагдахыг зөвшөөрөхөөсөө өмнө болон судалгааны явцад асуулт асуухыг зөвшөөрөх,
- 7) Хэрэв ямар нэгэн хүндрэл гарвал ямар төрлийн эмчилгээ хийлгэх боломжтой талаар мэдэх.
- 8) Судалгааг эхлүүлсний дараа оролцохоос бүрмөсөн татгалзах эсвэл оролцох тухай бодлоо өөрчлөх. Энэхүү шийдвэр хэрэв би судалгаанд хамрагдаагүй байсан бол авах байсан тусламж үйлчилгээ авах миний эрхэд нөлөөлөхгүй,
- 9) Гарын үсэг зурж, огноолсоны зөвшөөрлийн маягтын хуулбарыг авах
- 10) Судалгаанд оролцохыг хүсэх эсэхээ бодож үзэхдээ дарамт шахалтаас ангид байх.

Судалгааг Хүнс, Эмийн Захиргаа (ХЭЗ) зохицуулдаг эсэхийг таны судалгааны эмч танд хэлэх болно. Хэрэв энэхүү судалгааг ХЭЗ зохицуулж байгаа бол Холбооны хүнс, эм, гоо сайхны тухай хуулийн (ХХЭГСТХ) дагуу ХЭЗ миний судалгаанд оролцохтой холбоотой бүх мэдээллийг шалгаж, хуулбарлаж болно.

Хэрэв танд өөр асуулт байвал судлаач эсвэл судалгааны туслахаас асуух хэрэгтэй. Мөн та судалгааны төсөлд оролцогчдыг хамгаалах асуудлыг хариуцсан Байгууллагын хяналтын зөвлөл (БХЗ)-тэй холбоо барьж болно. Та (415) 476-1814 дугаарт Даваа-Баасан гарагт өглөөний 8:00 цагаас оройн 5:00 цаг хүртэл залгаж эсвэл UCSF Хүний Судалгааны Хамгаалалтын Хөтөлбөр, Box 1288, 490 Illinois Street, Floor 6, San Francisco, CA 94143 хаягаар захиа бичиж эсвэл irb@ucsf.edu хаягаар э-мэйл илгээн БХЗ-ийн албатай холбоо барьж болно.

Орчуулгын талаар мэдээлэл авахыг хүсвэл (415) 476-1814 дугаарт залгаж эсвэл irb@ucsf.edu хаягаар э-мэйл бичээрэй.